

“ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ” НААДМЫН ТАЙЛАН

2015 оны 08 дугаар сарын 10 өдөр

2015 оны 08 сарын 08 -09 өдөр Хүй долоон худагт Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 380 жилийн ойг тохиолдуулан 100 жилийн өмнө Их хүрээнд тэмдэглэдэг байсан Даншиг наадмыг сэргээн Монголын Бурхан шашны сүм хийдүүд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран ийнхүү Хүй долоон худагт тэмдэглэн өнгөрүүллээ. Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-аас Даншиг наадмын ерөнхий зохион байгуулах хороонд дарга П.Цогтбаатар, шашин, соёлын арга хэмжээ зохион байгуулах хороонд мэргэжилтэн Д.Өлзийсайхан нар оролцон ажиллаа.



Наадмын үеэр тус байгууллага бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж наадамчин олондоо үйлчиллээ. “Даншиг наадам-Хүрээ цам-2015” наадам нь энэ сарын 8-ны өдөр Чингисийн талбайд өглөө 06.00 цагт 600 гаруй лам, хуврагын хурал номын айлдвараар эхэлсэн. Нийслэлийн иргэд, сүсэгтэн олонд зориулж ном хурах ёслолоор эхэлсэн даншиг наадам Хүй долоон худагт үргэлжилэн Соёмбот туг залах ёслол, Мандал өргөх ёслол, Очирваанийн шүтээний тахилга, Өндөр гэгээний дүрийг залах ёслол, Цам харайх, Маани татах ёслол болсон.



Мөн “Азийн жороо хүлэг морин спортын холбоо” ТББ-тай хамтран жороо морины уралдаан зохион байгуулсан нь үзэгч түмний хүсэн хүлээсэн уралдаан байсан юм.



Түүнчлэн хүчит бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харваа болж олныг баясгасан юм. Мөн даншиг наадмын үеэр лам нарын мэтгэлцээн, урлагийн тоглолт, аялал жуулчлалын үзэсгэлэн боллоо.

Нийслэлийн аялалжуулчлалын газрын зохион байгуулсан аялал жуулчлалын үзэсгэлэн худалдаа.



Монгол наадам цогцолбор болон Хаадын зам жуулчны баазын хамтран зохион байгуулсан Айрагны баярын арга хэмжээний үеэр дэмбээ хурууны тэмцээн зохион байгууллаа.



“Даншиг наадам-Хүрээ цам-2015” шашин, соёлын наадамд түрүүлж, үзүүрлэсэн хүчит бөх, хурд шандсаа сорьж, айргийн тавд хурдалсан морьдын бай шагнал, цэц мэргэнээ уралдуулсан.



Шагналыг нийслэлийн ИТХ –ын дарга Д.Баттулга, Гандантэгчилэн хийдийн Их Шанзодба Л.Ариунжаргал, Да лам Х.Бямбажав, Дашчойлон хийдийн тэргүүн хамба Ч.Дамбажав, нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч С.Очирбат, нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл, нийслэлийн Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан орлогч Ц.Буяндалай, Даншиг наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн дарга, нийслэлийн ЗДТГ-ын дарга Ё.Гэрэлчулуун нар гардуулав.